Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
Газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны
өдрийн А/01 тоот тушаалын хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН
АЖИЛ АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ

№	Албан тушаал	Ангилал зэрэглэл	Батлагдсан орон тоо
1	Газрын дарга	ТЗ-10	1
2	Ерөнхий нягтлан бодогч	ТУ-8	1
3	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
4	Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТУ-5	1
5	Мэдээлэл технологийн асуудал хариуцсан ажилтан	ТЗ-5	1
6	Гэрээт ажилтан /жолооч, үйлчлэгч/		2
	Газрын удирдлагын хэлтэс		
7	Газрын удирдлагын хэлтсийн дарга	ТЗ-7	1
8	Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-6	1
9	Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
10	Газрын татвар, төлбөр, үнэлгээний асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
11	Суурь судалгаа, газрын мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
12	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
13	Газрын даамал	ТЗ-5	16
	Барилга, хот байгуулалтын хэлтэс		
14	Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга	ТЗ-7	1
15	Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-6	1
16	Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
17	Ерөнхий архитектор бөгөөд Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
18	Барилгын материалын үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1
19	Барилгын материалын лабораторийн шинжээч	ТУ-6	1
	нийт		35

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 03 өдөр | Дугаар А/02 | Дорноговь аймаг, Сайншанд сум

Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх заалт, 122.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Хөдөлмөрийн дотоод журмын 7.2'-т "Албан хаагч ажилдаа 08:30 минутаас хойш ирсэн тохиолдолд түүнээс хойших минут тутмыг 100 төгрөгөөр тооцон албан хаагчийн цалингаас суутган дундын санд хуримтлуулна" гэж нэмсүгэй.

2. Хөдөлмөрийн дотоод журмыг хэрэгжүүлж ажиллахыг нийт албан хаагчдад, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн /Ц.Энхмаа/-д даалгасугай.

3. Хөдөлмөрийн дотоод журмын 7.2'-т нэмэлт өөрчлөлт оруулсантай холбогдуулан энэхүү тушаалыг 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН

4422010004

Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын
газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 03-ны
өдрийн А/ 762 тоот тушаалын хавсралт

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ХӨДӨЛМӨРИЙН ДОТООД ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Дорноговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /цаашид "газар" гэх/ -ын хөдөлмөрийн дотоод журмын зорилго нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, албан хаагчийн эрх үүрэг, хариуцлагыг тодорхойлох, албан хаагчийг албан тушаалд томилох, чөлөөлөх, халах, тэдний хөдөлмөрийг оновчтой зохион байгуулах, урамшуулах, мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх, давтан сургах, үйл ажиллагааг төлөвлөх, тайлагнах, үнэлэх, мэдээлэх, байгууллага, иргэдтэй харилцах, хөдөлмөрийн дэг журмыг тогтоох, түүнийг сахихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Монгол улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Төрийн албаны тухай, Төсвийн тухай, Хөдөлмөрийн тухай, Захиргааны ерөнхий хууль, Барилгын тухай багц хууль, Газрын тухай багц хуулиуд болон Авлигын тухай хууль тэдгээрт нийцүүлэн гаргасан дүрэм, журам, энэ журмыг мөрдлөг болгон ажиллана.

1.3. Газар нь Барилга, хот байгуулалтын яам, Газар зохион байгуулалт геодези зураг зүйн газар, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргын емнө газрын харилцаа, барилга, хот байгуулалттай холбогдсон нэгдсэн бодлого шийдвэрийг боловсруулах, түүний хэрэгжилтийг зохион байгуулах, сумдын газрын даамлуудыг нэгдсэн удирдлагаар хангах, аймгийг хөгжүүлэх нийгэм эдийн засгийн зорилтуудыг биелүүлэх, газар ашиглалтын үр өгөөжийг дээшлүүлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх асуудлыг зохицуулалтаар хангаж ажиллана.

1.4. Хөдөлмөрийн дотоод журмын хэрэгжилтэнд хэлтсийн дарга нар болон хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж, хэрэгжилтийн явцыг даргад танилцуулж байна.

Хоёр. Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын удирдлага, зохион байгуулалт

2.1 Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газраас баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулна.

2.2 Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын даргатай зөвшилцөн Аймгийн Засаг дарга томилсон (цаашид "Газрын дарга" гэх) дарга удирдах бөгөөд газрын үйл ажиллагааг үр ашиг, үр нөлөөтэй удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүргийг Төсвийн ерөнхийлөн захирагчийн емнө хүлээнэ.

2.3 Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар нь Газрын удирдлагын хэлтэс, Барилга, хот байгуулалтын хэлтэс, Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори, Захиргаа аж ахуйн нэгжүүдээс бүрдэх ба тэдгээр нь

өөрсдийн хүлээсэн үүргийн дагуу ажил, үйлчилгээний гүйцэтгэл, үр дүнг газрын даргын өмнө бүрэн хариуцаж ажиллана.

2.4 Ажилтны үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг төрийн албаны төв байгууллагаас баталсан журмын дагуу тогтоосон хугацаанд үнэлж дүгнэнэ.

Хоёр. Албан тушаалд томилох, албан тушаалаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халах

2.1. Газрын дарга /Төсвийн шууд захирагч/ төрийн жинхэнэ албан хаагчийг томилохдоо Төсвийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд заасны дагуу томилон, үр дүнгийн гэрээ байгуулан ажиллана.

2.2. Төрийн жинхэнэ албан тушаалд анх орсон албан хаагчид туршилтын хугацааг 6-12 сар хүртэл хугацаагаар тогтоож болно. Туршилтын хугацаанд үр дүнгийн гэрээгээр хүлээсэн үүргийг хэрхэн биелүүлж, цаашид төрийн жинхэнэ албанд үр бүтээлтэй ажиллах чадвараа нотолж чадсан эсэхээс хамааруулан газрын даргын тушаалаар туршилтын хугацааг дуусгавар болгон ажилд томилох буюу ажлаас чөлөөлөх асуудлыг шийдвэрлэнэ.

2.3. Иргэнийг төрийн албан тушаалд томилох болон ажилд авахад дараах баримт бичиг бүрдүүлнэ.Үүнд:
2.3.1.төрийн албан хаагчийн анкет /Маягт №1/;
2.3.2.боловсрол, мэргэжлийн диплом, гэрчилгээ /үнэмлэх, сертификат/-ны нотариатаар баталгаажуулсан хуулбар;
2.3.3.намтар /3 үеийн/;
2.3.4.нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр;
2.3.5.иргэний үнэмлэхний хуулбар;
2.3.6.төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцсэн тухай болон Төрийн албаны тангараг өргөсөн тухай материал /төрийн үйлчилгээний албан тушаалд томилоход хамаарахгүй/ эрүүл мэндийн бичгийн хамт;
2.3.7.ажил байдлын тодорхойлолт;
2.3.8.зураг 4 хувь /4*6/;
2.3.9.ажилд орохыг хүссэн хувийн өргөдөл;
2.3.10.бусад.

2.4. Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллах иргэнийг газрын даргын тушаалаар томилж, чөлөөлнө. Хөдөлмөрийн гэрээг газрын дарга албан хаагчтай заавал бичгээр байгуулна. Хөдөлмөрийн гэрээнд заасан нөхцөл өөрчлөгдөх тохиолдолд уг албан хаагчтай харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

2.5. Хөдөлмөрийн гэрээнд дараах гол нөхцлийг тусгана:
2.5.1.ажлын байрны буюу албан тушаалын нэр;
2.5.2.албан тушаалын тодорхойлолтонд заагдсан ажил үүрэг;
2.5.3.үндсэн цалин буюу албан тушаалын цалин;
2.5.4.хөдөлмөрийн нөхцөл;
2.5.5.ажлын цаг;
2.5.6.гэрээний хугацаа.

2.6. Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн шинээр томилогдсон албан хаагчид байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн эрх, үүрэг, үр дүнгийн гэрээ, албан тушаалын цалингийн сүлжээ ба нэмэгдэл хөлс, шагнал урамшуулал, ажиллах нөхцөл, баталгаа зэргийг танилцуулна.

2.7. Шинээр ажилд томилогдсон албан хаагчид хувийн хэрэг хөтөлнө. Албан хаагчдын хувийн хэрэг хөтлөлт нь Төрийн албаны зөвлөлөөс батлагдсан журмын шаардлагыг хангасан байна.

2.8. Шаардлагатай тохиолдолд төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэх, үйлчилгээний албан тушаал хавсран ажиллах асуудлыг шийдвэрлэх бөгөөд цалингийн зөрүү болон нэмэгдэл хөлсийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу олгоно.

2.9. Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаалаас нь бууруулах, төрийн албанаас чөлөөлөх, түр чөлөөлөх, халахдаа Төрийн албаны тухай хуулийн 46, 47 дугаар зүйлд заасан үндэслэлээр шийдвэрлэх бөгөөд төрийн үйлчилгээний албан хаагчийн Хөдөлмөрийн гэрээг Хөдөлмөрийн тухай хуулийн 37, 38, 39, 40 дүгээр зүйлд заасан үндэслэлээр дуусгавар болно. Тушаалд ажлаас чөлөөлсөн болон халсан шалтгаан, үндэслэлийг тодорхой бичнэ.

2.10. Байгууллагын санаачилгаар албан хаагчийг ажлаас чөлөөлсөн тохиолдолд 1-3 жил хүртэл ажилласан ажилтанд 1 сарын үндсэн цалин, 4-6 жил хүртэл ажилласан ажилтанд 2 сарын үндсэн цалин, 7-9 жил ажилласан ажилтанд 3 сарын үндсэн цалинтай нь дүйцүүлэн тэтгэмж олгоно.

2.11. Албан хаагчид нь ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд албаны баримт бичиг, ажлын файл, эд хөрөнгийг хүлээлгэн өгч, холбогдох албан тушаалтнаар тойрох хуудсыг бөглүүлж, тооцоо хийсний дараа нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын дэвтэр, хувийн хэргээ авна.

2.12. Ажлын зайлшгүй шаардлагын дагуу гэрээт ажилтанг ажил гүйцэтгэх гэрээгээр ажиллуулж болно. Ажил гүйцэтгэх гэрээг газрын дарга гэрээт ажилтантай бичгээр байгуулах ба хариуцсан хэлтсийн дарга гүйцэтгэлд хяналт тавьж ажиллана.

Гурав. Захиргааны болон албан хаагчдын эрх,үүрэг

3.1. Захиргаа дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

3.1.1. Газрын эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилтыг үндэслэн алба хаагчийн ажлын байрны тодорхойлолтыг оновчтой тогтоож мөрдүүлнэ.

3.1.2. Хөдөлмөрийн сахилга дэг журмыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулж, албан хэргийн эмх цэгц, ажлын цаг ашиглалтын байдалд хяналт тавина.

3.1.3. Албан хаагчийг ажлын байр, бичиг хэргийн хэрэгсэл, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах ба төрийн албан хаагчийн ажлын байрны стандартад нийцсэн байна.

3.1.4. Хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам болон бусад дүрэм, журмыг батлан мөрдүүлж, байгууллагын веб сайтад байрлуулах.

3.1.5. Албан хаагчдын хөдөлмөрийн бүтээмж, ажил үйлчилгээний чанарыг дээшлүүлэх, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй нөхцөлийг хангах, өрөө тасалгааны аятай тохитой байдлыг сайжруулах.

3.1.6. Албан хаагчдын хөдөлмөрийн болон нийгмийн идэвхийг өрнүүлэхэд чиглэсэн чөлөөт цаг, амралтыг зөв зохистой өнгөрүүлэх талаар тухай бүр анхаарч тодорхой ажил зохион байгуулах.

3.1.7. Албан хаагчдын мэдлэг, мэргэшил, ур чадварыг дээшлүүлэх, давтан сургах ажилд дэмжлэг туслалцаа үзүүлэх.

3.1.8. Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, гал усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллах.

3.1.9. Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах зорилгоор жилд 1-ээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах арга хэмжээ авах. Ийнхүү эрүүл мэндийн үзлэгт

хамруулаагүй бол тухайн албан хаагчийн хүсэлтийн дагуу эрүүл мэндийн үзлэгт хамрагдахад цалинтай чөлөө олгох,
3.1.10.Албан хаагчдаас ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүргийн дагуу хийгдсэн үр дүнгийн гэрээний биелэлт болон эрхэлсэн ажлын чиглэлээр нь цаг үеийн асуудалтай холбогдсон үүрэг даалгаврыг өгч, түүний хэрэгжилт үр дүнг шаардах, шагнаж урамшуулах, хариуцлага хүлээлгэх асуудлыг зохих хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх.
3.1.11.Албан хаагчид нь албан үүргээ гүйцэтгэх явцдаа гэмт халдлагад өртөхөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хамгаалах талаар албаны удирдлага санаа тавьж, газрын асуудалтай холбоотой зөрчил маргаан шийдвэрлэх, газар чөлөөлөх зэрэгт цагдаагийн байгууллага, хамгаалалтын албатай хамтран ажиллана.
3.1.12.Албан хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх.

3.2. Албан хаагчид нь дараах эрх эдэлж, үүрэг хүлээнэ.
3.2.1. Албан хаагчид нь холбогдох хууль тогтоомжид заасан эрхийг эдэлнэ;
3.2.2. Өргөсөн тангарагтаа үнэнч байж, төрийн албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, төрийн байгууллага, албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлнэ.
3.2.3. Албан тушаалын тодорхойлолт, хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээнд заасан чиг үүргийг хэрэгжүүлж, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг шуурхай чанартай гүйцэтгэж, биелэлтийг хугацаанд нь эргэн танилцуулж, төрийн албаны захирах, захирагдах зарчмыг чанд баримтлан ажиллах, удирдах албан тушаалтны хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан шийдвэрийг биелүүлэх;
3.2.4. Албан хаагчид нь мэдээллийн самбар болон дотоод сүлжээнд байрлуулсан мэдээлэлтэй танилцаж, өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, дүн мэдээг бичгээр гарган, хариуцсан мэргэжилтэнд өгч нэгтгүүлэх;
3.2.5. Албан хаагчид нь эрхэлсэн ажилдаа идэвх санаачилга гаргаж, албан ажлын мэдлэг, мэргэшил, ур чадвараа байнга дээшлүүлж, ажлын цагийг үр бүтээлтэй бүрэн ашиглаж, үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж болон тогтоосон журмыг хатуу чанд сахиж мөрдлөг болгон ажиллах;
3.2.6. Албан хэрэг, бичиг баримтын нууцыг чандлан хадгалж, бичиг баримтыг стандартын дагуу боловсруулж, албан хэргийг архивт хугацаанд нь шилжүүлж байх;
3.2.7. Хөдөлмөрийн эрүүл ахуй, ариун цэврийг сайжруулах, гал усны аюулаас сэргийлэх болон архидан согтуурах, тамхины хор хөнөөлтэй тэмцэх талаар гарсан хууль, дүрэм, журмыг сахин биелүүлж, ажлын байрыг цэвэр, эмх цэгцтэй байлган, тавилга эд хогшил, техник, тоног төхөөрөмжийг ариг гамтай ашиглаж, ажлын цагаар ажил үүрэгт холбогдолгүй үйл ажиллагаа явуулахгүй байх;
3.2.8. Ажлын байранд болон албан үүргээ гүйцэтгэх явцдаа согтууруулах ундаа хэрэглэх, тамхи татах, бусдад ажил үүргээ гүйцэтгэхэд саад учруулах, хөндлөнгөөс үл оролцох, бие биедээ хүндэтгэлтэй хандах, хамт ажиллагсад болон удирдлаган дор байгаа албан хаагчид ажлын байрны болон сэтгэл зүйн дарамт, шахалт үзүүлэхгүй байх;
3.2.9. Албаны өмч, эд хогшил, техник хэрэгслийн ашиглалт хамгаалалтыг шаардлагын хэмжээнд байлгаж, ямар нэгэн зөрчил дутагдалгүй ажиллаж, өөрийн буруугаас болж гэмтэл учруулсан тохиолдолд хохирлыг нөхөн төлөх;
3.2.10.Өөрийн хувийн хэрэг болон үр дүнгийн гэрээг дүгнэсэн үнэлгээ зэрэгтэй танилцаж, хувийн хэрэгтээ жил тутамд баяжилт, хөдөлгөөн нэмэлт хийнэ;
3.2.11. Гадаад, дотоодод томилолтоор ажилласан, сургалтанд хамрагдсан тохиолдолд ирснээс хойш ажлын 5 хоногт багтаан илтгэх хуудсыг холбогдох хэлтэс, албан тушаалтанд тайлагнаж байх
3.2.12 Цалин хөлсөө нэмэгдүүлэх, албан тушаалын зэрэглэлээ ахиулах, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаагаа сайжруулах, техник хэрэгслээр хангуулах, дотоод гадаадын сургалтанд хамрагдахтай холбогдсон санал, хүсэлт болон шаардлагыг удирдах албан тушаалтанд амаар буюу бичгээр уламжлах;

3.2.12 Албан хаагчид нь холбогдох хууль болон энэхүү журмаар хүлээсэн үүргээ биелүүлэхдээ зөвхөн мэргэжлийн байр суурьнаас хандана;
3.2.13 Компьютер, техник тоног төхөөрөмжийн лацыг дур мэдэн хөдөлгөх, эд ангийг солих, байгууллагатай гэрээ, хэлцэл хийснээс бусад байгууллага, хувь хүнээр засвар үйлчилгээ хийлгэхийг хориглоно;
3.2.14 Ажлын бус цагаар гадны хүн дагуулж ажлын байранд нэвтрэхийг хориглоно;
3.2.15 Албаны эд хөрөнгө, техник хэрэгслийг хувийн зорилгоор ашиглах, гадны хүнийг компьютер, техник хэрэгсэл дээр ажиллуулах, тэднийг ажлын байранд хяналтгүй үлдээх, дадлагын оюутнаар ажил үүргээ гүйцэтгүүлэхийг хориглоно.

Дөрөв. Ёс зүйн зөрчил, түүнийг хянан шийдвэрлэх ажиллагаа.

4.1 Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрэм болон энэхүү журамд заасан хэм хэмжээг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүйг "ёс зүйн зөрчил" гэж үзнэ.

4.2. Нийт албан хаагчид "Ёс зүйн дүрэм"-ийг хэрхэн сахин биелүүлж байгаад "Ёс зүйн хороо" хяналт тавина.

4.3. Албан хаагчид Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай иргэдээс ирүүлсэн гомдол, хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсан мэдээллийн мөрөөр "Ёс зүйн хороо"-гоор хянан шийдвэрлүүлж, холбогдох арга хэмжээг авна.

4.4. Ёс зүйн хороо нь "Ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх журам" -ын дагуу үйл ажиллагаагаа явуулна.

Тав. Албаны ажлыг төлөвлөх, тайлагнах үнэлэх, мэдээлэх

5.1 Газар нь эрхэм зорилго, стратегийн зорилт, чиг үүргээ хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй ажиллана.

5.2. Газрын дарга үр дүнгийн гэрээ болон хөдөлмөрийн гэрээг албан хаагчидтай хууль тогтоомжид заасны дагуу тус байгуулна.

5.3. Хэлтэс болон албан хаагчид нь хагас жилийн тайлан, төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг тухайн жилийн 06 дугаар сарын 20-ны дотор; жилийн тайлан, төлөвлөгөөний биелэлт, үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээний биелэлтийг тухайн жилийн 12 дугаар сарын 15-ны дотор гаргаж хуулийн асуудал хариуцан мэргэжилтэнд өгнө.

5.4. Газрын төсвийн төслийг боловсруулах, батлуулах, захиран зарцуулах, тайлагнах ажлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу ахлах нягтлан бодогч, нярав хариуцан зохион байгуулна. Түүнчлэн албаны үйл ажиллагаанд зарцуулсан зардлыг зүйл, ангилалаар нь тооцож, бүтээгдэхүүний өртөгтэй холбон дүгнэлт хийж, даргын зөвлөлийн хуралд тайлагнаж байна.

5.5 Газрын хагас, бүтэн жилийн үйл ажиллагааны тайлан, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх зорилт, дээд байгууллагын захирамж, тогтоол шийдвэрийн биелэлтийн мэдээг холбогдох хэлтэс, мэргэжилтэнгүүд гаргах ба хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн, архив, бичиг хэргийн эрхлэгч нар нэгтгэн, дүгнэлт хийж, тайланг тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор гарган холбогдох газарт хүргүүлнэ.

Зургаа. Үр дүнгийн гэрээг дүгнэх

6.1. Газрын дарга нь төрийн албан хаагчдын үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин /үр дүнгийн гэрээний биелэлт/-ийг хагас, бүтэн жилээр дүгнэнэ.

6.2. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшин /үр дүнгийн гэрээний биелэлт/-г үнэлж өгсөн үнэлгээг үндэслэн Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, байгууллагын хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн акттай нийцүүлэн эрх хэмжээнийхээ хүрээнд Төсвийн шууд захирагч хууль тогтоомжид заасан арга хэмжээг хэрэгжүүлэх буюу энэ талаар эрх бүхий байгууллагад саналаа тавьж болно.

Долоо. Ажлын цагийн горим

7.1. Хөдөлмөрийн тухай хуулийн 70.1-д заасны дагуу албан хаагчдын 7 хоногийн ажлын нийт цагийн хэмжээ 40 цаг байна. Ажлын өдрийн үргэлжлэх хугацаа 8 цаг байх ба өглөө **8.00** цагт эхэлж, орой **17.00** цагт дуусна. Үдийн завсарлага **12.00** цагаас **13.00** цагийн хооронд байна.

7.2. Албан хаагч бүр ажилдаа ирэх, ажлаас явахдаа цаг бүртгэх хуруугны хээний аппаратад цагаа бүртгүүлж байна. Цагийн бүртгэлийг мэдээлэл технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн цаг бүртгэлийн программтай тулган ахлах нягтлан бодогчид гаргаж өгнө.

7.3. Албан хаагч ажилдаа 08:30 минутаас хойш ирсэн тохиолдолд түүнээс хойшхи минут тутмыг 100 төгрөгөөр тооцон албан хаагчийн цалингаас суутган дундын санд хуримтлуулна.

7.4. Ажлын цаг ашиглалтын бүртгэл хөтлөлтөд газар, хэлтсийн дарга, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн, ахлах нягтлан бодогч хяналт тавина.

7.5. Ажлын цагийн дундуур албан ажлаар гадуур явахдаа газар, хэлтсийн дарга, хамт ажилладаг албан хаагчид мэдэгдэнэ.

7.6. Албан хаагч нь хүндэтгэн үзэх шалтгаанаар ажилдаа ирэх бололцоогүй тохиолдолд газрын даргад урьдчилан мэдэгдэнэ.

7.7. Захиргааны санаачилгаар ажлын зайлшгүй шаардлагыг харгалзан эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг үндэслэн албан хаагчийг илүү цагаар ажиллуулж болно.

7.8. Гачигдал тохиолдсон буюу хүндэтгэн үзэх бусад шалтгаан /гэр бүлийн гишүүн нэмэх, сургалтанд хамрагдах гэх мэт/-ийн улмаас албан хаагчид чөлөө олгож болно. Албан хаагчид 30 хүртэл ажлын өдрийн цалинтай чөлөөг Газрын даргын тушаалаар олгож болно. Чөлөөний хуудсаар чөлөө аваагүй тохиолдолд ажил тасалсанд тооцно.

7.9. Жил бүрийн 1 дүгээр улиралд албан хаагчдын ээлжийн амралтын хуваарийг газрын даргын тушаалаар баталж гаргах бөгөөд амралтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлд заасны дагуу тогтооно.

7.10. Албан хаагчид жил бүрийн ээлжийн амралтыг биеэр эдэлнэ. Захиргааны шийдвэрээр ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй төрийн захиргааны албан хаагчид Төрийн албаны тухай хуулийн 61.1.9-т заасны дагуу менгөн урамшууллыг тухайн жилд багтаан олгоно.

7.11. Ээлжийн амралт олгох мэдэгдлийг Хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн ахлах нягтлан бодогч болон албан хаагчид хүргүүлнэ. Албан хаагч нь ажлаас халагдах тохиолдолд түүнтэй ээлжийн амралтын тооцоог заавал хийж байна.

7.12. Нийтээр амрах баярын өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүрийн хуваарийг газрын даргын тушаалаар батлуулан жижүүрт хувийг өгч, хэрэгжилтэнд хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажиллана. Хариуцлагатай жижүүрээр томилогдсон албан хаагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр утсаа салгах, зөрчил маргааныг тухайн өдөрт нь удирдлагад танилцуулах арга хэмжээ авна. Хариуцлагатай жижүүр илтгэх хуудас бичиж танилцуулна.

Найм. Албан хаагчдын харилцаа хандлага, дэг журам

8.1. Төрийн албан хаагчийн ёсзүйн дүрмийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллана.

8.2. Албан хаагч бүр төрийн албаны ажил үүргийн шаардлагад нийцүүлэн төлөв түвшин хувцаслана. Ажлын байранд этгээд содон хэв маяг, чөлөөт загвараар хувцаслахыг хориглоно. Барилгын хяналтын асуудал хариуцсан ажилтнууд нь хяналтаар ажиллах үедээ хөдөлмөрийн аулгүй бадал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын хувцас, хэрэглэл заавал өмсөнө.

8.3. Албан хаагчид нь хамт ажиллагсад болон үйлчлүүлэгчидтэй зөв боловсон харьцаж, харилцаа хандлагын зөрчил гаргахгүй байх.

8.4. Удирдах ба удирдуулах ёс зарчмыг хүндэтгэх, удирдах албан тушаалтантай зөв боловсон харьцаж, удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгавар зөвлөмжийг дагаж мөрдөн биелэлтийг эргэж тайлагнах.

8.5. Албан хаагчид ажлын байрныхаа эмх цэгц, ариун цэврийн хувьд бусдад үлгэр дууриалалтай байхаар зохион байгуулах

Ес. Албан хаагчдын цалин хөлс, нийгмийн баталгаа

9.1. Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг Засгийн газрын тогтоолоор баталсан цалингийн сүлжээг баримтлан тогтооно. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж буй ажилтны цалин хөлсийг ажилтантай байгуулсан гэрээний дагуу олгоно. Цалинг сард 2 хуваж / сар бүрийн 10, 25-ны өдөр/ тогтоосон хугацаанд олгож болно.

9.2. Албан хаагчдын ажлыг хагас, бүтэн жилээр дүгнэж шагнал урамшуулал олгох, ажлын үр дүнтэй нь холбогдуулан цалин хөлсийг нэмэгдүүлэх, нэмэгдэл хөнгөлөлт, нөхөн олговор олгох арга хэмжээг Төрийн албаны болон Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох журмын хүрээнд шийдвэрлэж байна.

9.3. Төрийн захиргааны албан хаагчийн зэрэг дэв, төрийн алба хугацааны хаасан нэмэгдэл, бусад нэмэгдэл, төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварын нэмэгдэл, бусад нэмэгдлийг хууль тогтоомжийн дагуу сар бүр албан тушаалын цалин дээр нэмэгдэл болгон тооцож олгоно.

9.4. Албан хаагчдын өдрийн хоолны хөнгөлөлтийг хууль тогтоомжийн дагуу төсөвт багтаан 8000 хүртэлх төгрөгийг олгож болно.

9.5. Албан хаагчдад амьдралын гачигдал тохиолдсон үед дараах тэтгэмж, тусламж байгууллагаас үзүүлнэ.

9.5.1. Албан хаагч, ажилтны гэр бүлийн гишүүн, төрсөн болон хадам эцэг эх түүнчлэн тус байгууллагад ажиллаж байгаад өндөр настны тэтгэвэрт гарсан хүн нас нөгчсөн тохиолдолд нэг удаа 200 000 хүртэлх төгрөгийн тусламж олгоно

9.5.2. Албан хаагч, ажилтан /эхнэр буюу нөхөр/ -ийн төрсөн ах дүү нас нөгчсөн тохиолдолд нэг удаа 100 000 хүртэлх төгрөгийн тусламж олгоно.

9.5.3. Гэр хорооло́лд амьдардаг албан хаагчд, ажилтаны амьжиргааны түвшинг харгалзан амьжиргааг дэмжих үүднээс тодорхой зорилгоор /тухайлбал: өвлийн бэлтгэл хангах .... г.м / жилд нэг удаа 450 000 хүртэл төгрөгийн тэтгэмж олгоно.

9.5.4. Албан хаагч, ажилтаны ам бүл, гэр орон сууц нь байгалийн гамшигт өртөхөд 500 000 хүртэлх төгрөгийн тусламж олгоно.

9.5.5. Шинээр гэр бүл болох, орон сууцанд ороход 500 000 хүртэлх төгрөгийн тусламж олгоно.

9.6. Албан хаагч, ажилтан өөрөө болон түүний гэр бүлийн гишүүд нь хүндээр өвдөж, өндөр төлбөртэй эмчилгээ хийлгэхээр болсон тохиолдолд байгууллагаас нэг удаа 500 000 хүртэлх төгрөгийн буцалтгүй тусламж олгоно.

9.7. Албан хаагч, ажилтаны гэр бүлд шинээр хүн мэндлэхэд нэг удаагийн тэтгэмж 100 000 төгрөгийг олгоно.

9.8. Байгууллагын албан хаагч, ажилтаны хүүхдүүдэд хүүхдийн баяр болон шинэ жилийн баярыг тохиолдуулан хүүхэд бүрд 30 000 хүртэлх төгрөгийн бэлэг өгнө.

Арав. Шагнал, урамшуулал олгох

10.1. Мэргэжлийн өндөр ур чадвар, идэвх санаачилга гарган албан үүргээ тогтмол чанартай биелүүлж, ажлын өндөр амжилт гаргасан, албаны болон төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ, төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, байгууллагын болон албан хаагчийн нэр хүндийг эрхэмлэн дээдэлж, мэдлэг мэргэжлээ байнга дээшлүүлэн ажиллаж байгаа төрийн албан хаагчид дараах урамшуулал олгоно.

10.1.1.Төрийн албаны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шагналд тодорхойлох

10.1.2. Иргэдийн төлөөлөгчдийн хурал болон Засаг даргын шагнал болон бусад байгууллагын шагналд тодорхойлох;

10.1.3.Засгийн газрын болон төрийн дээд шагналд тодорхойлох;

10.2. Хамт олны хурлаар хэлэлцэж, газрын оны шилдэг албан хаагчийг шалгаруулж, байгууллагын хүндэт өргөмжлөл, мөнгөн урамшуулал олгоно.

10.3. Төсвийн шууд захирагч нь төрийн албан хаагчид жилийн ажлын үр дүнгээр холбогдох журмыг баримтлан мөнгөн урамшуулал олгоно. Урамшууллын хэмжээ хэлбэрийг хууль тогтоомжид заасны дагуу тогтооно.

10.4. Салбарын тэргүүний цол, тэмдэг, яамны жуух бичгээр шагнагдсан тохиолдолд холбогдох журмын дагуу байгууллагаас олгох дагалдах мөнгөн шагналыг олгоно.

Арван нэг. Сахилгын шийтгэл ногдуулах

11.1. Албан хаагчдад Төрийн албаны тухай хууль болон Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

11.2. Сахилгын шийтгэлийг газрын даргын тушаалаар ногдуулна. Уг шийдвэрийг хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн албан хаагчид өөрт нь мэдэгдэх бөгөөд тушаалыг хувийн хэрэгт нь хавсаргана.

11.3. Хууль тогтоомжид зааснаас бусад дор дурдсан үндэслэл нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно:
11.3.1 Албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ хангалтгүй биелүүлсэн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй;
11.3.2 Албан хаагч нь урьдчилан мэдэгдээгүй, зохих зөвшөөрөлгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил тасалсан;
11.3.3 Ажлын цаг ашиглалт хангалтгүй байх, удаа дараа цаг бүртгэлийн төхөөрөмжид бүртгүүлээгүй, ажлаас хоцорсон;
11.3.4 Хэвлэмэл хуудсыг өөр зориулалтаар хууль бусаар ашигласан, хуурамч баримт бичиг, материал үйлдсэн;
11.3.5 Байгууллагаас зохион байгуулагдаж буй нэгдсэн арга хэмжээнд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр удаа дараа оролцоогүй;
11.3.6 Иргэдийн өргөдөл, гомдол, хариутай бичгийн хугацааг удаа дараа хэтрүүлсэн; 11.3.7 Дээд газраас ирсэн хугацаатай үүрэг даалгаврыг хугацаанд нь биелүүлээгүй;
11.3.8 Цалинтай болон цалингүй чөлөө, эмнэлгийн хуудсаар авсан чөлөөний хугацааг хүндэтгэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн,
11.3.9 Хөдөлмөрлөх үүргээ биелүүлэх явцдаа өөрийн буруугаас байгууллагад эд хөрөнгийн хохирол учруулсан тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулсан эсэхийг харгалзахгүйгээр хуульд заасны дагуу эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэнэ.

Арван хоёр. Бусад асуудлын талаар

12.1. Төрийн болон байгууллага, хувь хүний нууцыг хариуцдаг, эсхүл тэдгээр нууцтай албан үүргийн дагуу танилцсан албан тушаалтан уг нууцыг задруулах, хувийн зорилгоор ашиглахыг хориглох бөгөөд уг албан тушаалтан ажлын шугамаар олж мэдсэн нууцыг бусдад задруулахгүй байх үүрэгтэй.

12.2. Агентлаг, байгууллага хоорондын харилцаа, бичиг хэргийн урсгал, өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, архивын үйлчилгээ, байгууллагын нууцыг хамгаалах зэрэг асуудлыг холбогдох хууль тогтоомж, эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас тогтоосон журмын дагуу зохион байгуулна.

Арван гурав. Хөдөлмөрийн дотоод журам хүчин төгөлдөр болох

13.1 Энэхүү Хөдөлмөрийн дотоод журам нь Газрын даргын тушаалаар батлагдсан өдрөөс хүчин төгөлдөр үйлчилнэ.

13.2 Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлт оруулах тохиолдолд байгууллагын нийт ажилчдын хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

----oOo---

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/63 Сайншанд сум

Гамшгаас хамгаалах орон тооны бус штабыг шинэчлэн тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.3, 13.4, 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 339 дүгээр тогтоол, Шадар сайдын 2018 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн 120 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус газрын орон тооны бүтэц, зохион байгуулалтад өөрчлөлт орсонтой холбогдуулан гамшгаас хамгаалах орон тооны бус штабыг шинэчлэн тогтоосон шийдвэрт өөрчлөлт оруулан Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын мэргэжлийн ангийн бүтцийг нэгдүгээр хавсралтаар, Томилгоот бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар, Гамшгийн үед дайчлагдах бүлийн гишүүдийг гуравдугаар хавсралтаар, Гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэл дамжуулах журмыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус батлсугай.

2."Гамшгаас хамгаалах тухай хууль", "Мэргэжлийн ангийг зохион байгуулах заавар", "Гамшгаас хамгаалах орон тооны бус штабын дүрэм"-ийн дагуу томилгоот бүрэлдэхүүн, бүлгийн гишүүдийн үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай материал техник, багаж хэрэгслээр хангаж, нөөц бүрдүүлэх арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллахыг штабын Хангалт хариуцсан туслах /Д.Сайнтуяа/-д тус тус даалгасугай.

3.Гамшгаас хамгаалах хууль болон бусад хууль, тогтоомж, төлөвлөгөөнд заагдсан үүргээ шуурхай гүйцэтгэж ажиллахыг нийт томилгоот бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН

4400019000

Болорсууулсан: Ц.Энхмаа

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны
өдрийн 1/03 тоот тушаалын 1.. хавсралт

ГАМШГИЙН ҮЕИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БИЕ БҮРЭЛДЭХҮҮН ЗАРЛАН МЭДЭЭГЭЭР АЖИЛЛАХ ЖУРАМ

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Шаардлагатай үед холбоо барих
1	Цагаанхүүгийн Оюунсайхан	Газрын дарга	99013898	88052930 91180739
2	Цэрэн-янжин Баярмаа	Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга	96373557	96603557
3	Элбэг Нандинцэцэг	Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн	90880011	99208575 96444416
4	Хуягбаатарын Энхбат	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	94080202	99469969 95233792
5	Цогтбаатар Энхмаа	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн	95511159	89720151
6	Ухна Баярсайхан	Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	99825191	99803337 91616663
7	Дашням Алтанчимэг	Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн	88103001	99099342 91192965
8	Сарантуяа Болорчимэг	Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн	96965956	96200306
9	Сэрдамба Гэрэлцэцэг	Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	99616155	-
10	Олзвойн Оюунцэцэг	Газрын үнэлгээ, төлбөр, татвар болон инженер хайгуул мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн	99950529	99407984 95087755
11	Доржпүрэвийн Сайнтуяа	Ерөнхий нягтлан бодогч	86058383	95650123 89160959
12	Алтангадасын Менхтогтох	Жолооч	91154047	96601423 91174047

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны
өдрийн А/03 тоот тушаалын 2 хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ГАМШГИЙН ҮЕД ДАЙЧЛАГДАХ БҮЛГИЙН ГИШҮҮД

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Дашням Алтанчимэг	Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн	Бүлгийн гишүүн
2	Олзвой Оюунцэцэг	Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Бүлгийн гишүүн
3	Цэрэн-янжин Баярмаа	Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга	Бүлгийн гишүүн
4	Алтангадасын Мөнхтогтох	Жолооч	Бүлгийн гишүүн

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын даргын 2022 оны 07 дугаар сарын 07-ны
өдрийн А/103 тоот тушаалын 3 хавсралт

МЭДЭЭЛЛИЙН ДОХИОГООР АЖИЛЛАХ ЖУРАМ

Албаны дарга
Ц. Оюунсайхан 99013898, 6-р баг, Дампилын 17-6

Штабын дарга Х.Энхбат
94080202, 2-р баг, Нарлаг шанд 58-р байр, 27 тоот

Холбоо зарлан мэдээлэл хариуцсан туслах
Г.Болорчимэг, 6-р баг, Шинэ зууны 313-ийн 3-4 тоот

Сэргээн босголтын асуудал хариуцсан туслах
Э.Нандинцэцэг, 90880111, 2-р баг, Нарлаг шанд 105-09 тоот

Бүлгийн гишүүн
Ц.Баярмаа
96373557, 2-р баг, Нарлаг шанд хороллын Шизуока 52-4 тоот

Аюулгүй ажиллагааны асуудал хариуцсан туслах
Г.Гэрэлцэцэг, 99616855, 1-р баг, Шинэ зууны гудамж, 35-р байр, 11 тоот

Бүлгийн гишүүн
О.Оюунцэцэг, 99950529, 8-р баг, Алтанговь 2-ийн 245-43 тоот

Сургалт бэлэн байдал хариуцсан туслах
Ц.Энхмаа 95511159, 1-р баг, Шинэ зууны гудамж 32-р байр, 52 тоот

Гамшгаас хамгаалах нөөц хангалт хариуцсан туслах
Д.Сайнтуяа
86058384, 2-р баг, 18 айл, 18 тоот

Бүлгийн гишүүн
Алтанчимэг, 88103301, 3-р баг, Үзүүрийн 4-ийн 401 тоот

Хамгаалах арга хэмжээ хариуцсан туслах
У.Баярсайхан, 99825191, 1-р баг, Шинэ зууны гудамж 36-р байр 19 тоот

Бүлгийн гишүүн
А.Мөнхтогтох
91154047, 6-р баг, Жанчивын 21-1б тоот

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 21-ны
өдрийн А/ тоот тушаалын 1 хавсралт
105

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОМИЛГООТ БҮРЭЛДЭХҮҮН

№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар
1	Цагаанхүү Оюунсайхан	Газрын дарга	Албаны дарга
2	Хуягбаатар Энхбат	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	Штабын дарга
3	Сарантуяа Болорчимэг	Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан туслах
4	Ухна Баярсайхан	Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Хамгаалах арга хэмжээ хариуцсан туслах
5	Цогтбаатар Энхмаа	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн	Сургалт, бэлэн байдал хариуцсан туслах
6	Доржпүрэвийн Сайнтуяа	Ерөнхий нягтлан бодогч	Хангалт хариуцсан туслах
7	Э.Нандинцэцэг	Барилгын асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	Сэргээн босголт хариуцсан туслах
8	С.Гэрэлчимэг	Албан хэрэг хөтлөлт, архивын асуудал хариуцсан мэргэжилтэн	Аюулгүй ажиллагаа хариуцсан туслах

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын
газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 11-ны
өдрийн А/02 тоот тушаалын 5 дугаар хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН МЭРГЭЖЛИЙН АНГИЙН БҮТЭЦ

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/04 Сайншанд сум

Цалингийн санг шинэчлэн тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3, 46 дугаар зүйлийн 46.3.2 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлийн 103.3 дахь заалт, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, 2019 оны 275 дугаар тогтоолийн нэгдүгээр хавсралт, 2019 оны 276 дугаар тогтоолийн нэгдүгээр хавсралт, Байгууллагын "Төрийн үйлчилгээний албан хаагчийн ур чадварыг үнэлэх журам"-ын 2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус газрын албан хаагчдын цалинг шинэчлэн тогтоож, хавсралтаар баталсугай.

2. Цалингийн шатлал болон ур чадварын нэмэгдлийг цалингийн сангаас тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч /Д.Сайнтуяа/-д зөвшөөрсүгэй.

ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН

4422030147

Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын Газрын даргын 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн А/04 тоот тушаалын хавсралт

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧ АЖИЛЛАГСДЫН АЛБАН ТУШААЛ, АНГИЛАЛ ЗЭРЭГЛЭЛ, ЦАЛИН

№	Овог нэр	Албан тушаал	Албан тушаалын		Үндсэн цалин	Зэрэг дэв		Төрийн албанд ажилласан хугацааны нэмэгдлийн хувь	Бусад нэмэгдэл		
			Ангилал	Шатлал		Албан тушаалын зэрэг дэвийн ангилал	Нэмэгдлийн хувь		Хавсран гүйцэтгэсний	Нууцын	Ур чадвар
1	Ц.Оюунсайхан	Газрын дарга	ТЗ-10	5	1088657	Гутгаар зэрэг ахлах түшмэл	28%	10%			
2	Ц.Баярмаа	Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга	ТЗ-7	5	924456	Гутгаар зэрэг ахлах түшмэл	28%	20%			
3	Д.Сайнтуяа	Еренхий нягтлан бодогч	ТУ-8	5	797676			5%			30%
4	Ц.Энхмаа	Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1	642388						
5	С.Болорчимэг	Албан хэрэг хетелт, архивын асуудал хариуцсан ажилтан	ТУ-5	5	635776						30%
6	Э.Нандинцэцэг	Барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-6	5	853375			5%			
7	С.Гэрэлцэцэг	Инженерийн дэд бүтцийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	2	680286						
8	Б.Билэгдэлгэр	Хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	1	642388						
9	Э.Батболор	Барилгын материал үйлдвэрлэл, лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	2	680286						
10	Цэрэндолгор	Лабораторийн шинжээч	ТУ-6	2	630843						
11	У.Баярсайхан	Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн	ТЗ-6	3	773046	Дөтгөөр зэрэг дэс түшмэл	18%	10%	30%		

12	Х.Энхбат	Геодези, зураг зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	5	791532	Дөтгөөр зэрэг дэс түшмэл	18%	10%	30%	15%	
13	О.Оюунцэцэг	Суурь судалгаа, монитрингийн асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	3	718193			5%	30%		
14	Д.Жаргалсайхан	Газрын кадастрын асуудал хариуцсан мэргэжилтэн	ТЗ-5	3	718193			5%			
15	Д.Мядагмаа	Сайншанд сумын газрын даамал	ТЗ-5	3	718193	Дөтгөөр зэрэг туслах түшмэл	10%	10%			
16	Г.Батсүх	Иххэт сумын газрын даамал	ТЗ-5	2	680286	Дөтгөөр зэрэг дэс түшмэл	18%	5%			
17	И.Болортуяа	Дэлгэрэх сумын газрын даамал	ТЗ-5	4	754867			10%			
18	Б.Батбаяр	Эрдэнэ сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
19	З.Нямсүрэн	Алтанширээ сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
20	Г.Заяасайхан	Хөвсгөл сумын газрын даамал	ТЗ-5	3	718193	Гуттаар зэрэг ахлах түшмэл	28%	20%			
21	Б.Лханаажав	Сайхандулаан сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
22	Т.Золбоо	Айраг сумын газрын даамал	ТЗ-5	3	718193	Гуттаар зэрэг туслах түшмэл	12%	10%			
23	М.Отгонбат	Даланжаргалан сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
24	Г.Нямцэцэг	Өргөн сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
25	Д.Жавзан	Замын-үүд сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
26	Ж.Бат-Оргил	Замын-үүд сумын газрын даамал	ТЗ-5	5	791532			5%			
27	Г.Очирсүх	Улаанбадрах сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
28	Э.Одчимэг	Хатанбулаг сумын газрын даамал	ТЗ-5	1	642388						
29	А.Мөнхтогтох	Жолооч	ТҮ-3	4	543175						
30	Д.Сүхүяг	Үйлчлэгч	ТҮ-1	5	523405						

-----o-----

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/05 Дорноговь аймаг, Сайншанд сум

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1 дэх заалт, 83 дугаар зүйлийн 83.2 дахь заалт, 83.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус газрын нярав Басбишийн Батгэрэлийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Сайнтуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Гишүүн: С.Болорчимэг /Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Ц.Энхмаа /Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

О.Оюунцэцэг / Газрын үнэлгээ, төлбөр, татвар болон инженер хайгуул мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн /

Э.Батболор / Барилгын материалын лабораторийн эрхлэгч /

2.Б.Батгэрэлийн ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Сайнтуяа/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН

4422010014

Библиотекадан

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 07 өдөр Дугаар А/05 Дорноговь аймаг, Сайншанд сум

Ажил хүлээлцүүлэх тухай

Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1.1 дэх заалт, 83 дугаар зүйлийн 83.2 дахь заалт, 83.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Тус газрын нярав Басбишийн Батгэрэлийн ажил хүлээлцэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Д.Сайнтуяа /Ерөнхий нягтлан бодогч/

Гишүүн: С.Болорчимэг /Архив, албан хэрэг хөтлөлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

Ц.Энхмаа /Захиргаа, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн/

О.Оюунцэцэг / Газрын үнэлгээ, төлбөр, татвар болон инженер хайгуул мониторингийн асуудал хариуцсан мэргэжилтэн /

Э.Батболор / Барилгын материалын лабораторийн эрхлэгч /

2.Б.Батгэрэлийн ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн дотор хүлээлцэж дуусгахыг ажлын хэсгийн ахлагч /Д.Сайнтуяа/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН

4422010013

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 01 сарын 24 өдөр | Дугаар А/06 | Дорноговь аймаг, Сайншанд сум

Лабораторийн хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4 дэх заалт, Стандартчиллын үндэсний зөвлөлийн 2018 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" /MNS ISO/IEC 17025:2018/ стандартыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус газрын дэргэдэх Барилгын материалын лабораторийн менежментийн тогтолцоо, үйл ажиллагааг сайжруулахад шаардлагатай хөтөлбөр, төлөвлөгөөнүүдийг хавсралтаар батлсугай.

2. Лабораторийн Дотоод аудитын хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, Сургалтын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, Тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын хөтөлбөрийг гуравдугаар хавсралтаар, Эрсдлийн менежментийн төлөвлөгөөг дөрөвдүгээр хавсралтаар, Лаборатори хоорондын харьцуулалтад оролцох төлөвлөгөөг тавдугаар хавсралтаар, Дотоод хяналтын төлөвлөгөөг зургаадугаар хавсралтаар тус тус батлсугай.

3. Лабораторийн хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллахыг лабораторийн эрхлэгч /Э.Батболор/-д даалгасугай.

ДАРГА Ц.ОЮУНСАЙХАН

4422010017

Болорсруулсан: Э.Болдбаатар
Х...
А...

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2022 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн
А/06 тоот тушаалын 1 дүгээр хавсралт

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ДОТООД АУДИТЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаа, менежментийн тогтолцооны шаардлагад нийцэж байгаа эсэхэд дотоод аудитыг явуулж, лабораторийн менежментийн тогтолцоог үр дүнтэй хэрэгжүүлж, хадгалахад оршино.

Хоер. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчим

Дотоод аудит нь лабораторийн үйл ажиллагааны дотоодын хяналтыг хангах

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2022-2024 онд хэрэгжүүлнэ.

Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт

4.1. Дотоод аудитын үйл ажиллагааг лабораторийн эрхлэгч хариуцан зохион байгуулах ба жилд 1 удаа ГХБХБГ-ын даргын тушаалаар томилогдсон ажлын хэсэг дотоод аудитыг хийж, тайлагнана.

4.2. Лабораторийн эрхлэгч нь дотоод аудит явуулах тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж ГХБХБГ-ын даргаар батлуулж, хэрэгжүүлнэ.

4.3. Дотоод аудитын тайлан нь менежментийн дүн шинжилгээний оролт болно.

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. ГХБХБГазар нь лабораторийн дотоод аудитыг хариуцан зохион байгуулах ажилтнуудыг чадавхижуулах, сургаж дадлагажуулах

5.2. Лабораторийн үйл ажиллагаа менежментийн тогтолцооны шаардлагад нийцэж байгааг жил бүр тодорхойлох.

5.3. Дотоод аудитын шалгуур үзүүлэлтийг сайжруулах, нэмж баяжуулах

5.4. Дотоод аудитаар илрэх гажилт, үл тохирлыг багасгах, ижил төстэй үл тохирлыг давтан гаргахгүй байх арга хэмжээг үр дүнтэй авч хэрэгжүүлэх

Зургаа. Хүрэх үр дүн

Барилгын материалын лабораторийн үйл ажиллагаа нь "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага" /MNS ISO/IEC 17025:2018/ стандартын шаардлагад нийцэж улмаар сорилтын үр дүнгийн чанар хангагдахад нөлөөлнө.

Долоо. Шалгуур үзүүлэлт

Стандартын шаардлагууд, лабораторийн өөрийн бодлого, дүрэм журмын шаардлагууд.

-----oOo-----

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2022 оны .01.. дугаар сарын .24.-ний өдрийн
A/06. тоот тушаалын 2 дугаар хавсралт

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН 2 ЖИЛИЙН СУРГАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Сургалтын сэдэв	Хугацаа	Хамрагдах ажилтны тоо
	2022 он		
1	БХТ-ийн БМСШЛ болон өөр итгэмжлэгдсэн лабораторид дагалдуулан сургах сургалт	1,3-р улирал	2
2	"Хэмжлийн эргэлзээг тооцох нь" сэдэвт сургалт	1-р улирал	1
3	Ажлын байран дээрх сургалт	1,2-р улирал	1
4	Сорилт, шинжилгээний стандарт судлах дотоод сургалт	1-р улирал	2
5	Байгууллагын дотоод сургалт	Тухай бүр	2
6	Бусад байгууллагуудаас зохион байгуулж буй сургалт	Тухай бүр	2
	2023 он		
1	БХТ-ийн БМСШЛ болон өөр итгэмжлэгдсэн лабораторид дагалдуулан сургах сургалт	2-р улирал	1
2	"Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавигдах шаардлага MNS ISO/IEC 17025:2018" стандарт болон бусад холбогдох стандартуудын сургалт	Зарлагдсан хугацаанд	2
3	Ажлын байран дээрх сургалт	Тухай бүр	2
4	Сорилт, шинжилгээний стандарт судлах	Тухай бүр	2
5	Байгууллагын дотоод сургалт	Тухай бүр	2
6	Бусад байгууллагуудаас зохион байгуулж буй сургалт	Тухай бүр	2

Боловсруулсан:

Лабораторийн эрхлэгч: Э.Батболор /Э.Батболор/

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2022 оны .01. дүгээр сарын .12.-ний өдрийн
.A/06. тоот тушаалын 3 дугаар хавсралт

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ШАЛГАЛТ ТОХИРУУЛГЫН ХӨТӨЛБӨР

Нэг. Хөтөлбөрийн зорилго

Хөтөлбөрийн зорилго нь барилгын материалын лабораторийн багаж хэрэгслэл, тоног төхөөрөмжийг төлөвлөгөөт шалгалт тохируулгад хамруулах, шаардлагатай тохиолдолд үзлэг, хяналт, тохируулга хийх нөхцөлийг бүрдүүлж, сорилтын үр дүнгийн үнэн бодит байдлыг хангуулахад оршино.

Хоер. Хэрэгжүүлэх хугацаа

Хөтөлбөрийг 2022-2024 онд хэрэгжүүлнэ.

Гурав. Удирдлага, зохион байгуулалт

3.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг лабораторийн эрхлэгч удирдан зохион байгуулна.

3.2. Лабораторийн эрхлэгч шалгалт тохируулгын тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулж ГХБХБГ-ын даргаар батлуулан, хэрэгжилтийг хангуулна.

3.3. Лабораторийн багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмжийн шалгалт тохируулгын үйл ажиллагааг лабораторийн шинжээч хариуцан зохион байгуулах ба хэрэгжилтэнд эрхлэгч хяналт тавьж ажиллана.

3.4. Хэмжлийн багаж, тоног төхөөрөмжид шалгалт тохируулгыг чадавхитай лабораториор хийлгэнэ.

3.5. Лабораторийн эрхлэгч хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг гаргана.

Дөрөв. Хэрэгжүүлэх үйл ажиллагаа

4.1. Шалгалт тохируулгад хамруулах багаж хэрэгслэл, тоног төхөөрөмжийн бүртгэлтэй байх ба бүртгэлийг шинжээч хөтлөн ажиллана.
4.2. Хэт ачаалсан, буруу харьцсан, эвдэрсэн тохиолдолд зохих арга хэмжээг авч, сорилтыг гүйцэтгэхийн өмнө чадавхитай лабораториор шалгалт тохируулга хийлгэнэ.
4.3. Шинэ багаж, хэрэгслэл, тоног төхөөрөмжийг ашиглахын өмнө чадавхитай лабораториор шалгалт тохируулга хийлгэх шаардлагатай.

Тав. Хүрэх үр дүн

Барилгын материалын лабораторийн шалгалт тохируулгын үйл ажиллагаа нь сорилтын үр дүнгийн чанар хангагдахад нөлөөлнө.

Зургаа. Шалгуур үзүүлэлт

Эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн шалгалт тохируулгын хэмжлийн эргэлзээ, өргөтгөсөн эргэлзээний өөрчлөлтийн утга.

-----oOo-----

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын 2022 оны .01. дүгээр сарын .24.-ний өдрийн .A/06. тоот тушаалын 4 дүгээр хавсралт

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН 2 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Эрсдэл		Шийдвэрлэх арга хэмжээ
1	Ажилтантай холбоотой эрсдэл	Ажилтны мэдлэг боловсрол, ур чадвар сул байх	Менежментийн тогтолцооны баримт бичиг, Чанарын гарын авлага, лабораторийн дүрэм, журмыг танилцуулах
			Ажилтны журмын дагуу сургах, хяналт тавих, ур чадварт хяналт үнэлгээ хийх
			БХТ-ийн БМСШЛ болон өөр бусад чадавхитай лабораторид дагалдуулан сургах
			MNS ISO/IEC 17025:2018 стандартын холбогдох сургалтуудад хамруулах
			Ажлын байран дээр дагалдуулан сургах, сорилт, шинжилгээний стандартыг бүрэн судлуулах, дотоод сургалт зохион байгуулах
2	Тоног төхөөрөмжтэй холбоотой эрсдэл	Эвдрэл, гэмтэл гарах	Үйл ажиллагааг зогсоож, учир шалтгааныг судлан тогтоох
			Тоног төхөөрөмжид засвар үйлчилгээг хийлгэх
			Дотоод шалгалтыг хийх, шаардлагатай тохиолдолд шалгалт тохируулгыг чадавхитай байгууллагаар хийлгэх
3	Хүсэлт, гэрээний шинжилгээтэй холбоотой эрсдэл	Сорилт хийлгэх шаардлагыг буруу ойлгох	Лабораторийн эрхлэгч нь хэрэглэгчийн ирүүлсэн хүсэлтэд дүн шинжилгээг хийж, ойлгомжгүй, эргэлзээтэй, алдаатай гэж үзсэн тохиолдолд дахин дэлгэрэнгүй мэдээллийг хэрэглэгчээс авах, тодруулах арга хэмжээг авах
		Хэрэглэгчтэй харилцан уялдаа холбоогүй байх	Сорилтын арга, хугацаа зэрэг шаардлагатай мэдээллийг хэрэглэгчид тодорхой тайлбарлан өгөх
4	Тайлантай холбоотой эрсдэл	Буруу ба зохисгүй тайлан	Лабораторийн эрхлэгч сорилт шинжилгээг хянаж, сорилтын тайланг хэвлэн гаргах, буруу тайлан хэрэглэгчид очсон тохиолдолд нэн даруй мэдэгдэж, тайланг татан авч, залруулах арга хэмжээг авах
5	Үл тохирох ажилтай холбоотой эрсдэл	Үүнийг арилгахгүй, засварлахгүй, давтах	Үл тохирох ажил илэрсэн тохиолдолд журмын дагуу зохих арга хэмжээг авах, учир шалтгааныг нь тодорхойлсны дараа залруулах арга хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх

Боловсруулсан:

Лабораторийн эрхлэгч Э.Батболор /Э.Батболор/

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2022оны ..а. дүгээр сарын 11.-ний өдрийн
..А/06.. тоот тушаалын 5 дугаар хавсралт

ЛАБОРАТОРИ ХООРОНДЫН ХАРЬЦУУЛАЛТАНД ОРОЛЦОХ 2 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Д/Д	Сорилтын түүхий эдийн төрөл	Стандарт	Д/Дугаар:
2022 он			
1	Элс	Физик механик шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох MNS 2916:2014	ГХ-SA-01/2022
2	Портландцемент	Цемент–олон ширхэглэлтэй стандарт элс хэрэглэн турших арга, MNS 0976:2008	ГХ-CE-01/2022
3	Хөөсөн полистрол хавтан	Барилгын дулаан тусгаарлах материал-нягт тодорхойлох арга MNS ISO 29470:2010, Ус шингээлт тодорхойлох MNS ISO 29767:2010	ГХ-PO-01/2022
2023 он			
1	Хөөсөн полистрол хавтан	Барилгын дулаан тусгаарлах материал-нягт тодорхойлох арга, MNS ISO 29470:2010, Ус шингээлт тодорхойлох MNS ISO 29767:2010,	ГХ-PO-01/2023
2	Тоосго	Физик механик шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох MNS 0982:1980, MNS 0983:1980	ГХ-Br-01/2023
3	Явган зам талбайн хавтан	Физик механик шинж чанарын үзүүлэлтийг тодорхойлох	ГХ-Ti-01/2023
4	Дайрга	Барилга,замын ажилд хэрэглэх уулын нягт чулуулаг-хайрга, дайрга. Физик-механик шинж чанар тодорхойлох арга MNS 2998:2009	ГХ-CRS-01-2023

Тайлбар: БХТ-ийн Барилгын материалын сорилт шинжилгээний лаборатори болон итгэмжлэгдсэн улсын болон хувийн лаборатори хоорондын харьцуулалтад орохоор төлөвлөсөн болно.

Боловсруулсан:

Лабораторийн эрхлэгч Э.Батболор /Э.Батболор/

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын
даргын 2022 оны .01. дүгээр сарын .19.-ний өдрийн
..A/06..тоот тушаалын 6 дугаар хавсралт

БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ЛАБОРАТОРИЙН ДОТООД ХЯНАЛТЫН 2 ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Сорилтын зүйл	Тоо хэмжээ	Хугацаа	Хариуцах эзэн
1	Хадгалагдаж буй дээжид сорилтыг давтан хийлгэх	Элс	1	2022-04 2023-04	Лабораторийн эрхлэгч
2		Дайрга	1		
3	Үл мэдэгдэх дээжид сорилт гүйцэтгүүлэх	Тухайн жилд ирсэн дээжинд	1	2022-09 2023-09	
4		Тухайн жилд ирсэн дээжинд	1		
5	Нягтыг тодорхойлох	Хөөсөн полистрол хавтан	1	2022-10 2023-10	
6		Дайрга	1		
8	Тоног төхөөрөмжид хяналт шалгалт хийх	Хатаах шүүгээ	3 удаа /сард/	2022 2023	Шинжээч
9		Аналитик жин	2 удаа /сард/	2022 2023	
10		Гидро статик жин	2 удаа /сард/	2022 2023	
11	Сорилтын үр дүнд дүн шинжилгээ хийх	-	Тухай бүр		Лабораторийн эрхлэгч, шинжээч
